

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 7 ХОНОГИЙН ТАЙЛАН
/2022.09.30 - 2022.10.07/

2022.10.07

Дархан-Уул аймаг

№	Ажлын чиглэл	Үйл ажиллагааны гүйцэтгэл
Барилга хот байгуулалтын хэлтэс		
1	Барилга угсралтын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Засгийн газрын 213-р тогтоолын дагуу барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг 3 барилгад олгосон. Үүнд: <ul style="list-style-type: none"> - “Номин реалтор” ХХК-ний 36м х 60м хэмжээтэй зоорьгүй 2 давхар үйлчилгээний барилга - “Ногоо боловсруулах, савлах цехийн барилга” 20*18 хэмжээтэй зоорьгүй нэг давхар барилга - Дархан-Уул аймаг Дархан сум 15-р баг хабитат, мангирт чиглэлийн 2 дугаар контурын ажил ✓ Барилгын ажлын зөвшөөрөл аваагүй барилга угсралтын ажил гүйцэтгэсэн зөрчилтэй 2 барилга байгууламжид барилгын ажлыг зогсоож холбогдох хуулийн дагуу арга хэмжээг авсан. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Дархан сум, 13-р багт байрлалтай 4505100263 нэгж талбарын дугаартай “Атаман стиль” ХХК - Дархан сум, 12-р багт 4506102794 нэгжталбарын дугаартай “Сангийн Жигүүрт” ХХК
1	Инженерийн дэд бүтцийн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Дархан-Уул аймаг, Орхон суманд хэрэгжиж байгаа ногоо хадаглах агуулахыг барилга болон ногоо савлах барилгад захиалагчийн техник хяналтыг хэрэгжүүлсэн. ✓ Дархан хотын хэмжээнд байрлах авто замын зураглал талбайн хэмжээг гаргаж тохижилт үйлчилгээний газарт хүргүүлсэн. ✓ 6,7-р багийн 2 -р хэсгийн ажлын газар чөлөөлөлтийн ажилд айл өрхүүдтэй уулзаж чөлөөлөх ажил бүрэн дууссан. ✓ Аймгийн хэмжээнд үйлдвэрийн зориулалттай цэвэрлэх байгууламжийн судалгааг хавсралт маягтын дагуу гаргаж БХТ-д хүргүүлсэн.
	Барилгын материал үйлдвэрлэл	<ul style="list-style-type: none"> ✓ Очир бетон ган ХХК бетон зуурмагийн үйлдвэрийн ашиглалтанд оруулах комисст ажилласан. Суурьт зуурмагийн /силос/ байрлуулсан байдал, экспертизээр батлагдсан ажлын зураг, БХТөвд магадлал хийгдсэн зураг төсөл, гүйцэтгэгч компанитай хийгдсэн гэрээ зураг баримтуудыг шалгасан ✓ Дэлхийн банкны сургалтанд цахимаар хамрагдав. ✓ Монгол улсад цементийн импортын татвар тэглэсэнтэй холбоотойгоор 2022.10.05-ны өдөр Дархан-Уул аймгийн хэмжээнд ажиллаж буй бетон зуурмагийн 6 үйлдвэрт үзлэг шалгалт хийж ажиллаа. Аймгийн МХГ-ын улсын байцаагч С.Цэвэржавжаа-ын хамт түүхий эдийг хаанаас нийлүүлдэг болон түүний орлогын баримтуудыг газар дээр нь үзэж шалгасан. Удаан хадгалагдсан эсвэл чулуужсан цементийг дахин нунтаглан нийлүүлж болзошгүйг анхааруулж, худалдан авч буй цементийн чанар стандарт шаардлагадаа хүрч буй эсэхийг шалгадаг эсэх, өөрсдийн дотоодын лабораторидоо энэ төрлийн шинжилгээг хийж үйлдвэрлэлд оруулдаг эсэхийг шалгасан
Газрын удирдлагын хэлтэс		
1	Суурь судалгаа, газрын мониторинг	1.
2	Газрын кадастрын чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудаар хэмжилт хийлгэсэн 6 иргэний материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Хонгор сумын / тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагуудаар хэмжилт хийлгэсэн/ нэгж талбараа хуваах хүсэлт гаргасан 3 иргэний материалыг хүлээн авч хувааж мэдээлийн санд оруулсан. ✓ Өмчлөлийн газраа худалдах, өвлүүлэх, бэлэглэх гэрээгээр шилжүүлж байгаа нийт 17 иргэний цахим хүсэлтийг мэдээллийн санд өөрчлөлт хийж, кадастрын зургийг гаргаж өгсөн. ✓ Дархан-Уул аймгийн Шарын гол сумын найрамдал талбайд зохион байгуулагдсан “Алтан намар -2022” хөдөлмөрийн яармаг, нээлттэй хаалганы өдөрлөгт оролцож, нийт 45 иргэнд 13 төрлийн үйлчилгээ үзүүлж

		ажиллалаа.
3	Геодези, зураг зүйн чиглэлээр	<ul style="list-style-type: none"> ✓ Хаягийн зургийн дагуу 8 иргэн, 4 аж ахуйн нэгжийн эзэмшлийн газар, үл хөдлөх эд хөрөнгөд хаяг дугаар олгосон. ✓ Шинээр үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ авахаар /хувийн сууц , гараж, барилга байгууламж, хуваалт / хэмжилт хийлгэсэн 12 иргэн, 3 аж ахуйн нэгжийн материалыг хүлээн авч мэдээлийн санд оруулж кадастрын зураг гаргасан. ✓ Геодези, зураг зүй, кадастрын зураглалын ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй “Гео од”, Ёлт сүрвэй” ХХК-ний хийж гүйцэтгэсэн доорхи ажлыг актаар хүлээн авсан. ✓ Дархан сум 14-р баг “Миний Монгол цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилтын улаан шугам /Усан оргилуур, явган зам / ✓ Орхон сум. Ногоо боловсруулах савлах цехийн цахилгаан хангамжийн гүйцэтгэл ✓ Орхон сум. Баян-Өлзийт баг Дэлгэрийн гудамжны гэрэлтүүлэгийн гүйцэтгэл ✓ Дархан сум. 8-р баг “Номин реалтор” ХХК-ний худалдаа үйлчилгээний төвийн барилгын улаан шугам ✓ Аймгийн Нийтийн аж ахуйн үйлчилгээний газарт Дархан сумын сул талбайн зургийг гаргаж өгсөн. ✓ Цагдаагийн газрын мөрдөн байцаах тасагт шалгагдаж байгаа гэмт хэргийн бүртгэлийн 996, 998 дугаартай гомдол мэдээлэлд өгөгдсөн цэгийн байршлыг харуулсан зургийг гаргаж хүргүүлсэн. ✓ ГЗБГЗЗГ-аас багуудын нэр, солбицолыг зөв эсэхийг шалгаж санал ирүүлэх тухай албан бичгийн хариуг хүргүүлсэн. ✓ Дархан сумын ГЗН салбар зөвлөлийн хурлыг 2022 оны 10 сарын 03-ны өдөр 14 цагт Дархан сумын Засаг даргын орлогч П.Ихбаярын өрөөнд хийсэн. Дархан сумын газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг хийхэд шаардагдах хөрөнгө орон нутгийн төсөвт суугаагүй байна. Иймд энэ ажлыг хийж гүйцэтгэх мөнгө санхүүгийн асуудлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргуулах саналыг Засаг даргад танилцуулж шийдвэрлүүлэхээр болсон. Багуудын Засаг дарга нарын оролцоо чухал байгаа тул багийн Засаг дарга нарт танилцуулж чиглэл хүргүүлэхээр тогтсон.
Захиргаа аж ахуйн чиглэл		
2	Мэдээллийн технологи, нярав	<p>Мэдээлэл: 70376471 нээлттэй утсаар 0 иргэн /Нүүж өөр өрөөнд орсон тул утасны үзүүр орж ирээгүй тул/, байгууллагын Facebook хуудсанд ирсэн 3 иргэн, ААНБ-ын асуултанд хариулт өгөв. 2022-10-06-ны өдөр цахим төвд ажиллан иргэдэд газрын цахим системийг хэрхэн ашиглах талаар заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.</p> <p>Мэдээлэл технологийн чиглэлээр: Байгууллагын цахим хуудсанд 9-р сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, Шарын гол суманд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгийн мэдээг оруулав. Байгууллагын фэйсбүүк хуудас болон Шарын гол сумын газрын даамлын фэйсбүүк хуудсанд Шарын гол суманд зохион байгуулагдсан нээлттэй хаалганы өдөрлөгийн мэдээг оруулав.</p> <p>1 компьютерт сканер таниулж өгөв. *.h265 өргөтгөлтэй файлыг нээх, хөрвүүлэх програм хангамжийг хайж олов.</p> <p>Нярав: Газрын удирдлагын хэлтсийн мэргэжилтнүүдэд 3 ширхэг нэгж талбарын хувийн хэргийн хавтас олгож, кадастрын мэдээллийн санд өөрчлөлт оруулсны төлбөрийн баримт 13 ширхэгийг хүлээж авч бүртгэв. Шаардах хуудсаар 2 төрлийн 61 ширхэг бараа материал олгов. Бараа материалын 9-р сарын зарцуулалтын нэгтгэлийг ня-бо-д гаргаж өгөв.</p>

Тайлан боловсруулсан:

Г.Нямдорж

Хянасан:

Газрын удирдлагын хэлтсийн дарга

Г.Нямдорж

